



Otgonbayar E.:

Someday, I will sail for Antarctica...

"I am crossing the bridge between two cultures on a horse; I experience through a Mongolian mindset, but conceptualize through a Western imagination," Otgonbayar E. states, an artist gaining admiration in Germany. We sat down to converse with this unique personality, whose paintings have been compared to labyrinth like puzzles.

Э.Отгонбаяр:

Нэг л өдөр Антарктидийг зорино доо

Их хөлийн газар болох Герман улсад амьдарч, уран бүтээлээ туурвиж буй Э.Отгонбаяр өөрийгөө "Хоёр тивийг холбож яваа хөтөлгөө морьтой хүн. Би монгол ухаанаар харж, европоор сэтгэж чаддаг" гэж тодорхойлсон удаатай. Хүмүүст оньсого мэт санагдахуйц өвөрмөц бүтээлүүдийн эзэнтэй ярилцлаа.

-Нүд эрээлжлэм олон өнгөтэй, хэтэрхий гэмээр нягт дүрслэлтэй, гэсэн атлаа хөдөлгөөнтэй, заримдаа стерео зургийг санагдуулам бүтээлүүдийг та асар том талбайд урладаг. Эзэлхүүн хийгээд өнгө, дүрслэлийн ийм "түрэмгийлэл"-ээр үзэгчдэд юуг харуулахыг хүсдэг вэ?

-Бүтээл болгон өөрийн гэсэн онцлогтой байдаг. Хүмүүс аливааг хүлээн авах, харах өнцөг нь өөр байдаг учраас би ямар нэгэн тайлбар өгвөл тэрхүү утгаас нь хазайж байна гэсэн үг. Учир нь амьдрал нэгдмэл утгаар оршин тогтнодог. Ертөнцийн юмс үзэгдэл өөр хоорондоо харилцан хамааралтай. Ганцаар оршин тогтнодог зүйл гэж энэ хорвоод үгүй. Бидний амьдрал, цаашлаад байгаль дэлхий ч тоолж барамгүй олон зүйлээс бүрддэгээрээ тун баялаг. Тийм учраас миний бүтээлүүдийн бичил жижиг хэсгийг нарийн харж байгаад бүхэлд нь харахыг оролдоорой. Энэ асуултынхаа хариултыг та тэндээс олж мэдрэх болно. Үгээр илэрхийлэх боломжгүй сонин содон зүйлс амьдралд олон бий. Гэвч үүнийг уран зургаар л илэрхийлэх боломжтой.

-Ж.Чинбат гэдэг эрхэм "Э.Отгонбаяр буддист арга барил буюу шүтээн урлалаар абстракт зураг зурсан нь, түүн дотроо маш этгээд сонин дүрслэл бүхий мянга мянган хүн, амьтнаар баялаг өрнүүн түүх өгүүлдэг нь барууныханд сонирхолтой санагддаг биз" хэмээн таны тухай нийтлэлдээ дурджээ. Харин та 1998 оноос хойш хоёр сая орчим морь зурсан гэв үү. Нэг талбай дээр

On large canvases, you paint intricate, densely cluttered, colorful patterns that seem as if they are moving. Your art reminds me of when a TV has no signal and static noise snow appears. With such an outspoken style and choices of color, what do you wish to communicate through your art?

Every artist, and their artworks have their own unique expression. Because art is subjective, and everyone interprets it differently, I stray from giving definitive explanations about my artworks. I do believe there is an objective, Absolute reality- but how an individual approaches the materialistic world is relative. However, although experiences are relative and subjective, nothing is really independent and free- everything is interconnected. Our lives, and nature in general, are all composed of complex connections. Thus, my art aims to capture how the universe is made of intricate tiny parts that are interconnected and by zooming out, you see how these parts come together to make a whole. The answer to your question is to be felt from this concept of interdependence of parts and wholes. This concept can only be effectively expressed through art, in my opinion.

Chinbat J. once said, "Otgonbayar's Buddhist style can be compared with monks' art of worship. His unique abstract expression of thousands of tiny people, or animal capture within them our culture and history. Westerners are most captured by that." It is also said that you have painted about a million horses



хамгийн олныг зурсан нь аль бүтээл вэ?

-Нэг бүтээл дээр хэдэн хүн, амьтны дүрс зурсан нь надад чухал биш. Гэхдээ л хүмүүс асуугаад байдаг юм. Нэгэн дүү маань миний зурсан бүх морийг компьютерийн тусламжтайгаар тоолоод "Хоёр сая орчим байна" гэсэн. "Туушин" зочид буудлын хойморт байрладаг 720x440 сантиметр хэмжээтэй бүтээлд 70 орчим мянган адууг хийсвэр байдлаар дүрсэлсэн юм.

-Одоогоос дөрвөн жилийн өмнө шүү дээ.

Берлинд 20 мянган уран бүтээлч байдаг тухай та ярьсан байсан. Энэ тоо бүр л нэмэгдсэн байх даа. Өрнө, дорныг холбосон хөтөлгөө морьтой зураачийн маань тэднээс ялгарах гол өнгө юу вэ. Монгол ахуйг абстракт дүрслэлээр харуулсан бүтээлүүдийн тань хажуугаар өрнөдийн урлаг судлаачид, шүүмжлэгчид, үзэгчид лав дуугүй өнгөрдөггүй байх аа?

-Берлин хот бол дэлхийн уран бүтээлчдийг соронз мэт татаж байгаа газар. Жил ирэх тусам энд суурьшиж уран бүтээлээ туурвих хүсэлтэй уран бүтээлчид олон орноос зуу зуугаараа нэмэгдэн ирж байна. Газар зүйн байрлалын хувьд төдийгүй амьдрахад дарамт багатай, эрх чөлөөг мэдрүүлдэг газар бол яах аргагүй Берлин хот юм. Олон үндэстний хүмүүс оршин суудаг энэ газарт хэн нэгнийг, аль эсвэл соёлыг даган дуурайхгүйгээр яг өөрийнхөөрөө байж болдог. Миний хувьд, бусдын нөлөөнд автахасаа илүү Монголын уран бүтээлч гэдгээрээ танил болохыг эрхэмлэдэг. Ер нь өөрт байгаа соёлыг бусдад түгээх сайхан шүү дээ. Хүмүүс бүтээлүүдийг маань хараад "Ийм зураг урьд нь огт харж байгаагүй юм байна" гэж хэлдэг. Үүнээс сайхан магтаал гэж юу байх вэ.

-Берлин хотод та анх 2005 онд суралцахаар очсон юм билээ. Хэн гэдэг эрхэмд шавь орж байв?

-Тэр үед би хэн нэгэнд шавь ороогүй. Уран зургийн боловсролыг Монголдоо эзэмшсэн 25 настай чөлөөт уран бүтээлч байлаа. Тийм болоод ч тэр үү Германд ирээд хэн нэгэнд шавь орох бодол байсангүй. Харин өөрийгөө илүү хөгжүүлж, дэлхий ертөнцтэй танилцахыг эрмэлзэж байв. Эхний хоёр жилд маш их үзэсгэлэн үздэг байсан. Тэгж явахдаа өөрийгөө ямар түвшинд, хаана яваагаа мэдэрсэн дээ. "Хурдхан л уран бүтээлдээ орохсон" гэж яардаг байж. Гэхдээ эхлээд герман хэлний шалгалтдаа тэнцэх ёстой байлаа. Үүний дараа урлаг судлалын чиглэлээр Берлиний Урлагийн их сургуулийн харъяа Institute for Art in Context-д гурван жил суралцаж, 2010 онд Master of Arts-ийг төгссөн.

-Сургуулиа төгсөөд "Зураг" гэдэг галерей байгуулж, дараа нь "OTGO" болгон өөрчилсөн. Берлин дэх энэхүү арт галерей тань хоёр



since 1998. In which of your artworks did you fit the most horses?

People always ask me exact numbers- how many horses or people I have fit into one painting is not important to me. One of my mentees used a computer program to count them and said there were around 2 million horses on one of my pieces. One of my other pieces, located in "Tuushin" Hotel, is 720x440 cm big, and is said to contain 70,000 horses.

Four years ago, you said that there are about 20,000 artists living in Berlin. The number has increased, I am sure. How do you stand out, our horse riding artist crossing the bridge between the East and the West? I am sure Western art critics, art majors and researchers have commented on your abstract expression of our culture.

Berlin is a magnet for artists and creators of all sorts. Every year, hundreds of artists come to Berlin to showcase their talent. Politically, people are not oppressed- they feel free to express, experiment and create. Berlin is definitely a place you feel most free. Because it is so multicultural, you do not feel the pressure to assimilate, or change, and you can freely be you. Rather than feeling pressured to assimilate, or change according to how others view my art, I personally feel most pressured from my Mongolian roots. It is my calling and duty to express my culture and heritage. When they see my art, they usually comment, "I have never seen anything like this!" I do not think there is a better compliment than that.

You moved to Berlin in 2005 to study. Who was your mentor when you first arrived?

At the time, I did not have a mentor. I had graduated



салбартай. Санхүүжилтээ анх яаж босгосон бэ. Байрны түрээсээс эхлээд өртөг зардал ихтэй биш үү?

-Уран бүтээлч гэж дуудуулах сайхан ч уран бүтээлээрээ амьдралаа авч явна гэдэг амаргүй. Гэвч би өөртөө итгэлтэй, зоримог шийдвэр гаргасан. Эрсдэлээ өөрөө үүрч, сайн найз нөхдийн дэмжлэгтэйгээр 2010 онд "Зураг" галерейгаа байгуулж байлаа. "Урд хормойгоороо хойд хормойгоо нөхнө" гэдэг шиг олон цаг эрч далайцтайгаар ажилладаг байсан юм. Түүнээсээ ч их туршлага хуримтлуулж, танилын хүрээгээ тэлсэн. Ажил руугаа явж байхад гудамжинд хүнгүй шахам байдаг байсан бол ажлаасаа тараад харьж явахад мөн л хүн цөөтэй байдаг байв. Миний хувьд, бүтээлүүдээсээ олсон орлогоороо санхүүждэг. Германд тухайн галерейг ажиллуулж байгаа хүнийх нь нэрээр нэрлэдэг болохоор 2013 оноос "OTGO" болгон өөрчилж үйл ажиллагааных нь цар хүрээг хумьсан. Одоо өөрийнхөө уран бүтээлүүдэд анхаарлаа төвлөрүүлэн ажиллаж байна. Цаг хугацааны явцад том хэмжээтэй бүтээл туурвих шаардлагатай болсон. Тийм учраас том, жижиг хоёр урланд уран бүтээлээ туурвиж, тэндээ байнгын үзэсгэлэн гаргадаг болсон доо.

"Берлинд амьдардаг уран бүтээлчдэд боломж их. Орлого нь багасч, төлөх татварынх нь хэмжээ буураад ирэхээр хорооных нь хүн ирж судалж, санаа тавина. Түрээсээ төлж чадахгүй боллоо гэхэд орлого нь нэмэгдтэл тэр хүний өмнөөс төлдөг. Тэтгэмжийн сангуудтай ч холбож өгнө. Ер нь тухайн уран бүтээлчийг ажилгүйчүүдийн эгнээнд оруулахгүй тулд ихээхэн анхаардаг" гэж ярьсан тань сайхан санагдаж байна. Уран

with an Art Degree in Mongolia before moving to Berlin, so I was not seeking a mentor at the time. I was looking to grow internally, open up my mind and expand my horizons. The first few years, I saw every single gallery I could find to fully realize my vision, and understand my own state of mind, and identity. "I need to immediately start creating," I told myself as I felt the pressure of time and necessity. But first, I needed to complete my course learning German. Afterwards, I entered the Institute for Art in Context at the Berlin University of Arts and in three years, completed my Master's Degree.

After graduating, you opened "ZURAG" gallery, and shortly after, you opened a second gallery, "OTGO". How did you initially finance your galleries? Starting with rent, I am sure it is expensive to run galleries.

It is an honor to carry the title "artist", but it is financially challenging to live solely by that name. I made a confident, bold decision at the time. Carrying all the risk myself, and with a little help from my friends, I opened ZURAG in 2010. There is a saying in Mongolian culture, "Repairing the front of the skirt with the back of the skirt" - I was working non-stop, making ends meet. But I gained a lot of experience, and met a lot of people in the industry. I used to go to work and go home when the streets were empty. I solely fund myself through my art. In Germany, galleries are usually named after the artist working the place, and so my gallery came to be known as OTGO. Now I am more focused on my own art. As time passed, I started displaying my own small and large-scaled artworks through various galleries around Berlin.

бүтээлчид гэдэг хил хязгааргүй найзууд. Тэд танд хэр тусалдаг вэ. Галерейгаа ажиллуулахад хотын захиргаанаас ч юм уу ямар нэгэн хөнгөлөлт, дэмжлэг үзүүлдэг үү?
-Герман улсын иргэд, ялангуяа уран бүтээлчдийг энэ тал дээр анхаарна. Харин би тус улсад амьдардаг ч Монгол Улсын иргэн хүн. Тиймээс эндэхийн холбогдох байгууллагаас дэмжлэг авах боломж бараг байдаггүй. Урлагийн салбар учраас татвар нь бусад салбарыг бодвол арай бага юм даа.


"Дүрслэх урлагийн салбарт 40 нас хүрээгүй хүнийг онгилодоггүй" ... Энэ бол таны хэлсэн үг. Харин ч эсрэгээрээ биш үү. Нас яваад ирэхээр хүн илүү хашир, магадгүй аймхай болно. Уран бүтээлчийн хувьд, огцом, зоримог шийдлийг бүтээлдээ тусгах нь ч багасах болов уу. Тэгэхээр урлагийнхан ирмүүн, дэврүүн, онгироо байж гэмээнэ сайн уран бүтээл туурвих ч юм билүү. Та юу гэж бодож байна вэ. Хэдэн жилийн өмнө хэлсэн дээрх үгнээсээ одоо буцмаар санагддаг уу?

-Арай өөр утгаар хэлсэн үг л дээ. Ер нь дүрслэх урлагийн ертөнцөд хүлээн зөвшөөрөгдөх амаргүй. Энэ бол үзэгчдийн урлагийн боловсролтой их, бага хэмжээгээр хамаатай. Тэр дундаа залуу уран бүтээлчдийг тийм ч хурдан хүлээн зөвшөөрдөггүй юм. Давааны цаадахь давааг давсаар байж, олонд өөрийгөө болон бүтээлүүдээ таниулж, ойлгуулж байж нэр хүндийг олдог. Дүрслэх урлагийн түүхээс харахад 40 нас хүрээгүй байхдаа од болсон уран бүтээлчид цөөхөн байдаг.

-Монголоос гадна Герман, Голланд, Швед, Швейцар, Франц, Япон, Чех, Энэтхэг зэрэг олон оронд та үзэсгэлэнгээ гаргасан. Дэлхийн уран зургийн ертөнцөд ер нь юу болж байна вэ. Тэд –измээс татгалзаад эхэлчихсэн үү, аль эсвэл сэргэн мандлын үе рүүгээ буцаад "алхаж" байна уу. Уран зураг гэдгийг өрнөдөд өнөөдөр хэрхэн тодорхойлж байна вэ?

-Уран бүтээлч хүн ямар нэгэн -изм-д баригдалгүйгээр бүтээж туурвих хэрэгтэй. Орчин үед интернэтийн давуу талыг ашиглаж, урлагийн түүхийн бүх цаг үеийн хөгжлийг нэг дороос харах, ажиглах, сурах боломжтой болсон. Тийм учраас урлаг хүссэн, хүсээгүй шинэчлэгдэн өөрчлөгдөж байна. Сүүлийн 20 жилийн технологийн хөгжилтэй ямар нэгэн байдлаар холбогдож, аль эсвэл өрсөлдөж, байр сууриа алдахгүйн тулд цаг үеэ мэдэрч, хувьсан өөрчлөгдөхөд орчин үеийн хүмүүсийн сэтгэхүй их нөлөөлөх болсон. Германы





үзэгчдийн урлагийн мэдрэмж, боловсрол маш өндөр түвшинд байдаг.

-Бидэнтэй нэгэн цаг үед амьдарч буй хамгийн алдартай зураач гэвэл та хэнийг нэрлэх вэ?

-Ихэнх уран бүтээлч бүтээлээ илэрхийлэх "хэл"-ээ олчихвол тэрхүү "хэл"-ээрээ л туурвиад байдаг. Гэтэл Gerhard Richter тухайн цаг үеэ мэдэрч, байнга хувьсан өөрчлөгдөж байдаг хүн. Тийм учраас энэ цаг үеийн хамгийн хүлээн зөвшөөрөгдсөн уран бүтээлч болж чадсан.

-Хамгийн сүүлд аль улсад лекц уншив?

-Зургаа зурахын зэрэгцээ судалгааны ажил хийж, зураг зурж байх үедээ түүнийгээ олон талаас нь бодож тунгаах дуртай. Энэ бүхнээс урган гарсан шинэлэг санаагаа хүмүүстэй хуваалцаж, мэтгэлцэх сонирхолтой учраас заримдаа илтгэл тавьдаг юм. Өнгөрсөн гуравдугаар сард Германы "Rotary club Kloster Zinna"-д илтгэл тавилаа.

-Ази, Европын хотуудад зураач нар гудамжинд,

"Artists living in Berlin have a lot of opportunities. When their profits fall, and their taxes decrease, someone from the art commission comes to investigate and console. When the artist cannot afford rent, the commission funds them until they can stand on their own again. They also connect you with places that can grant you pensions or scholarships. Generally, they take good care of artists not to let them fall into unemployment," you said before. Artists are essential creators of culture. How much care do they provide you in Germany? Do you get any support from the state to run your galleries?

German citizens and the state invest a lot into the Arts. Although I reside there, I am still a Mongolian citizen. Thus, it is hard to officially get any support from the German state. The art industry has a lower tax, and that helps.

"In the art industry, anyone under 40 must not get too much praise," you said in the past. Has your mind changed? As people get older, they become more stubborn, fearful and conservative. Artists should be

голын эрэг дээр уран бүтээлээ туурвиж байгаа харагддаг. Олон жилийн уламжлалт хотын соёлын нэгэн өнгө төрх нь болсон гэх юм уу даа. Гэхдээ тэд хэр хангалуун амьдардаг бол. Байгалийн зураг, хүмүүсийн хөргийг зураад хангалттай орлого олж чаддаг болов уу?

-Хуучин цагт гадаа суунгаа гудамж, талбай, байгалийн зураг зурдаг мэргэжлийн уран бүтээлчид байлаа. Харин одоо хүмүүс дуртай зүйлдээ цаг заваа зориулж, чөлөөт цагаа өнгөрүүлж байгаа хэрэг. Дээр хэлсэнчлэн энд хүмүүсийн урлагийн боловсрол өндөр учраас хүүхдүүд нь багаасаа уран зураг, хөгжмөөр хичээллэдэг. Эзэмшсэн мэргэжлээсээ гадна чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, урлагаас таашаал авах зэрэг олон шалтгаанаар хүмүүс нь зураг зурах дөртэй, хөгжим сайхан тоглодог нь надад таалагддаг. Хөрөг зураг зурдаг хүмүүсийг "Хангалттай сайн орлоготой" гэж бодохгүй байна. Гэхдээ тэдний дунд үнэхээр авьяастай хүмүүс байдаг байх. Тэгээд ч зарим нь их мөнгө олох зорилгоор бус, дуртай зүйлээ хийж амьдралдаа

radical, experimentative and fearless. Don't you think that art is born out of chaos and ego?

I meant something else by that. Generally, it is hard to be accepted and celebrated in the art industry. This is dependent on the audiences' knowledge and understanding of art and culture movements. Young artists have a harder time establishing themselves, and getting recognition. They must overcome many obstacles to gain respect, and be recognized in the eyes of the public. From an art history standpoint, there are only a few artists who have gained fame before 40.

Other than in Mongolia, you exhibited your work in Germany, Holland, Sweden, Switzerland, France, Czech Republic, Japan, and India. How does the art industry vary from culture to culture? Are they resisting –isms? Are they re-entering the Renaissance age of hyper productivity in any way? How is art defined and interpreted in foreign countries these days?

Artists must create without getting compressed into –isms. Due to modern technologies, and readily available abundant sources of knowledge, they must constantly learn from history. Whether we want it or not, art is constantly evolving. In the past 20 years, people have been rapidly evolving through technology, competition, and out of fear of being outdated. The German public is highly educated in the field of Arts, and they have finely refined taste compared to other places, I thought.

If you had to name an accomplished modern artist from our era, whom would you name?

Most artists, if they are lucky enough to find their distinct voice to communicate their inner universe, they usually stick to that voice. But Gerhard Richter is constantly changing his voice, and each one authentic and distinct in its own way. And so he is undoubtedly, one of the leading artists of our era.

Where and when did you last give a lecture?

While painting, I also conduct substantial research work and implement my research into my art as well. Because I like to share with my associates and friends, and have intellectual discussions about my research, I give lectures. I last lectured in March at a German "Rotary Club Kloster Zinna".

In Asian and European cities, artists exhibit their artworks in the streets, along riverbanks or in parks. This is an old tradition that has almost become an essential part of the culture. I wonder if they make enough from putting their works on the streets? Portrait caricatures, city scenery paintings- do they earn enough from these?



сэтгэл хангалуун явдаг юм. Надад тийм найз нөхөд олон бий.

-Антрактидад очиж үзсэн үү. "Антрактидийн дэлгэмэл хөрөг"-ийг та бүтээсэн байна шүү дээ. Багагүй судалгаа, цаг хугацаа шаардсан байх даа?
"Очиж үзэхсэн" гэж боддог. Нэг л өдөр Антрактидийг зорино доо. Харин энэхүү 300x900 сантиметр хэмжээтэй зургийг зурах гэж их ядарсан. Хүн төрөлхтөн байгаль орчинтойгоо буруу харьцсанаас үүдэлтэйгээр бий болсон цаг агаарын өөрчлөлтөөс болж ургамал, амьтдын зарим төрөл устаж үгүй болж байна. Цаашлаад хүн төрөлхтний оршин тогтнолд ч аюул заналхийлэх боллоо. Дэлхийн дулаарлын улмаас эхлээд мөс, дараа нь хүн төрөлхтөн аажмаар "хайлан" урсаж байна.

Байгаль дэлхий сүйдэж буй бодит байдлыг хараад сэтгэл эмзэглэдэг. Үүний илэрхийлэл бол миний уран бүтээл болох "Антарктика панорама" юм. Оцон шувууны хувь заяа их сэтгэл хөдөлгөсөн. Энэ

In the olden times, professional and respected artists used to sit outside painting the streets, parks, and nature. Nowadays it is more of a side hobby, aside from their regular job. Most people with a EU passport have the means to get educated in the arts, and develop their creative capacities- they have taken some form of art or music classes at some point in their lives. I cannot say that they earn enough just from painting on the streets. But there are highly talented portrait painters, of course. Many artists enjoy creating art as an end in itself, and do not expect to make a living out of it. I have many friends as such.

Have you been to Antarctica? One of your paintings of Antarctica gained high recognition, I'm sure you had to do a lot research.

Someday, I will sail for Antarctica. I struggled a lot to complete that 300x900 cm painting. Due to human activity, the environment is suffering a great measure. Climate change is to be our foremost priority- it is critically affecting our ecosystems, destroying plants and animals. We are all in critical danger. Climate



амьтнаас бид өөрсдийгөө олж харж болно. Бид энэ амьтан болон ирээдүй хойчийнхоо төлөө ямар нэгэн зүйл хийх хэрэгтэй. "Антарктика панорама" их шүүмжлэл агуулсан бөгөөд гунигтай бүтээл юм. Өнгө будаг цас, мөс, оцон шувуутайгаа уйлан хайлан урсдаг.

-Берлинд буддистууд хэр олон байдаг вэ. "Бурхны зургийг гараараа бус, бясалгаж буй мэт сэтгэл, оюунаараа бүтээдэг. Энэ үед яг л бясалгаж байгаа мэт шинэ эрч хүчийг мэдэрдэг. Зураач хүн бурхдын дүрийг бүтээхдээ хамгийн сүүлд мэлхийг нь тодруулснаар бурхад амилдаг" гэж та хэлжээ. Хэр олон бурхныг амилуулсан бэ?

-Буддын гүн ухааны холбогдолтой шүтээн зураг 600 орчмыг хийж судалсан. Гэхдээ би энэ чиглэлээр зурахаа болиод арав гаруй жил болж байна. Хүн төрөлхтнийг сэрээх Буддын гүн ухаан өдөр ирэх тусам өргөн дэлгэрч байгааг би мэдэрдэг. Берлинд жилд дунджаар 15 мянга орчим хүн Христийн шашнаас татгалзаж, тэдний багахан хувь нь Буддын гүн ухааныг сонирхон судалж эхэлдэг тухай мэдээлэл уншиж байлаа.

-Уран зураачийн хувьд дэлхийн дэвжээнд гарах амбицаа та хэдийнэ илэрхийлсэн. Зорилгодоо хүрч чадсан уу?

-Өөртөө итгэлтэйгээр уран бүтээлээ туурвиж байхад цаг хугацаа бүгдийг харуулна. Бодож санасан зүйлс, хийх ажил маш их байна. Нэг зүйлийг хэлэхэд, уран бүтээлч хүнд хийж амжаагүй бүтээл нь дандаа гайхамшигтай санагддаг.

-Ярилцсанд баярлалаа. Танд амжилт хүсье!

С.Тулга

change is first melting the glaciers, but eventually, we will all melt away. My heart deeply aches watching this tragedy. To express this sentiment, I created my painting, "The Antarctica Panorama". The endangered livelihoods of penguins call my deepest concern. We can see ourselves reflected in endangered species too, and we must make significant changes immediately. In my painting, the colors, brush strokes melt away along with the ice, snow and the penguins.

How prominent is Buddhism in Germany? You once said, "Paintings of Gods and deities are not to be merely painted, but to be meditated on. During this process of creating a sacred painting, you are recharged with divine energy. To complete the sacred portrait of a God, you finish with the pupil of the eyes, thereby, breathing life into the portrait." How many Gods have you painted and breathed life into?

I have created about 600 paintings of Buddhist Gods. But it has been over 10 years since I changed my subject. The time of our Awakening, and the gaining of God consciousness for humanity is approaching- I increasingly feel it everyday. I have read somewhere that every year, around 15,000 people turn away from the Catholic Church in Germany, and many of them turn to Buddhist teachings.

You have expressed your ambition to become a world acclaimed artist. Would you say you have reached your end goal?

When you confidently keep creating, your path is bound to lead you wherever you are meant to go. I still have a lot of dreams and goals I am working hard towards. Artists highly romanticize and idealize their vision for their art before creating it- I cannot say I have reached my ideals.

Thank you for your time. Wish you all the best!

Battulga S.

WELCOME TO GALLERIA ULAANBAATAR LUXURY SHOPPING CENTER

MUST VISIT DESTINATION
AT THE HEART OF ULAANBAATAR



OPENING HOURS:
EVERYDAY 10:00AM-10:00PM

THE WORLD'S LARGEST CASHMERE STORE /2.500 sqm/

GOBI

MONGOLIAN CASHMERE

PREMIUM MONGOLIAN CASHMERE BRAND

☎ 7004-8888

📍 GobiCashmere



GOYO

CASHMERE

LUXURY MONGOLIAN CASHMERE BRAND

☎ 7711-5353

📍 GOYOCashmereOfficial



LITTLE SHEEP

THE WORLD'S LARGEST HOT POT RESTAURANT /430 SEATS/

☎ 7511-2233

📍 LittleSheepHotPotMongolia



Galleria Souvenir

WHERE TRADITION COMES TO LIFE

☎ 7505-6006

📍 GalleriaSouvenir



COME AND SHOP WITH US



PRIME LOCATION IN DOWNTOWN ULAANBAATAR:

LOCATED NEXT TO
THE PARLIAMENT HOUSE
OF MONGOLIA

GALLERIA ULAANBAATAR
SHOPPING CENTER